



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/424

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ны "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирусын цар тахлын тохиолдол нэмэгдсэнтэй холбогдуулан тусгаарлалтад ажилласан эмч нарын хоолны зардалд зориулж 4,286,000 (дөрвөн сая хоёр зуун наян зургаан мянган) төгрөгийг зарцуулсугай.


2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах 4,286,000 (дөрвөн сая хоёр зуун наян зургаан мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



Аймгийн Засаг даргын 2021 оны  
10 дугаар сарын 06 өдрийн 44/24  
дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

| № | Зардлын нэр  | Тоо хэмжээ | Нэгжийн<br>үнэ | Нийт дүн  |
|---|--------------|------------|----------------|-----------|
| 1 | Өглөөний цай | 182        | 5,000          | 910,000   |
| 2 | Өдрийн хоол  | 174        | 9,000          | 1,566,000 |
| 3 | Оройн хоол   | 181        | 10,000         | 1,810,000 |
|   | Дүн          |            |                | 4,286,000 |